

**ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2025 ОНЫ
“ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ”-ИЙН ХӨТӨЛБӨРИЙН ТАЙЛАН**

2025.12.02

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжилт
1	Стратегийн үйл ажиллагаа 1. Хүний нөөцийн чадавхийг сайжруулах замаар байгууллагын соёл, ёс зүйг байгууллагад нэвтрүүлэх, хэвшүүлэх	• Төвийн Ёс зүйн хороо нь батлагдсан дүрэмтэй. • Төвийн гадаад /ил тод байдал гэсэн хэсэгт/ болон дотоод /ёс зүй гэсэн хэсэгт/ цахим хуудсанд “Эмнэлгийн мэргэжилтний ёсзүйн хэм хэмжээ”, “ЭХЭМҮТ-ийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтаны биеэ авч явах соёл, ёс зүйн даган мөрдөх журам” зэрэг бусад холбогдох хууль, журам, тушаал шийдвэрийг байршуулан, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан нарыг мэдээллээр ханган, урьдчилан сэргийлэх зорилгоор ёс зүйн салбар хороонд ирсэн өргөдөл гомдолд дүн шинжилгээ хийж, зөвлөмж өгч ажиллаж байна. • ЭМС-ын 406, 189 тоот тушаал, хурлаас гарсан зөвлөмж, ёсзүйн хэм хэмжээтэй холбоотой мэдээ мэдээллийг эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан нарт танилцуулах ажлыг зохион байгуулан эмч, сувилагч нарын яриа, төвийн дотоод, гадаад цахим хуудас болон “Ёс зүйн самбар”-т байршуулж тогтмол мэдээлж байна. /Зөвлөмж, талархал, ёс зүйн дүрэм, журам, тушаал, үнэлгээний хуудас, ёс зүйн сургалт/ • 2025 онд шинээр ажилд орж байгаа 150 ажилтан, албан хаагчдад Ёс зүйн дүрмийг танилцуулан, шалгалт авч, хяналт тавьсан байна. • 2025-05-06-ны өдөр “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй ба эрх зүй” сэдэвт сургалт нийт 326 удирдлагууд болон эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчид нарт орсон бөгөөд сургалтанд суусан нийт хүмүүс кредит тооцсон. • Шинээр орж байгаа нийт 150 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчдаас ЭМС-ын А/406 тоот тушаалын мэдлэг сорих шалгалтыг авсан. • Үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн байгууллага эмнэлгээр үйлчлүүлэхдээ баримтлах эрх, үүргийг танилцуулсан нийт 10 самбарыг байршуулав. • 2025 оны А/17 дугаар тушаалаар ЭХЭМҮТ-ийн дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороог байгуулж, ЭМЯ-ны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны 2025 оны 25/08 дугаар тогтоолоор ЭХЭМҮТ-ийн дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороог 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр 3 жилийн хугацаанд

		томилж, баталгаажуулсан. Тушаалыг Төвийн гадаад вэб хуудсанд байршуулсан. • Төрийн албан хаагчийн тухай хуулийг чанд мөрдүүлэх, эмч мэргэжилтэнгүүдэд хуулийг сурталчилах, ёс зүй харьцаа хандлагыг бүх шатанд дээдлэх тухай 7 заалт 4 бүлэг, 18 ажлын төлөвлөгөөг Төвийн захирлаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж, 2025 оны эхний хагас жилийн ажлын тайланг ЭМЯ-ны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороонд хүргүүлж, тайланг гадаад вэб хуудсанд байршуулсан. • Ёс зүйн салбар хорооны үйл ажиллагааны ил тод байдлыг хангах чиглэлээр Төвийн гадаад вэб хуудсанд ёс зүйн салбар хорооны гишүүдийн танилцуулга, ёс зүйн дүрэм журмууд, хийх ажлыг төлөвлөгөөг байршуулсан. • Ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулахаа “Ёс зүйн зөрчлийг үл тэвчих сэтгэлгээг хэвшүүлье” сэдэвт 2 сарын аяныг 2025.10.23 - 2025.12.23-ны хооронд зохион байгуулахаар удирдамжийг гарган, нийт тасаг нэгжид хүргэж ажиллаж байна. Удирдамжийг гадаад вэб хуудсанд байршуулсан.
2	Стратегийн үйл ажиллагаа 2. Хүний нөөцийн удирдлага, төлөвлөлтийн тогтолцоог боловсронгуй болгож, хүний нөөцийн хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлж, түүнд тулгуурлан хүний нөөцийн төлөвлөлтийг хийж, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх	• “ЭХЭМҮТ-ийн дүрэм, зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлах тухай” ЭМС-ын 2025 оны А/54 тоот тушаалыг үндэслэн ерөнхий захирлын 2025 оны А/29 тоот тушаалаар төвийн бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн баталсан. • Ерөнхий захирлын 2025 оны А/32 тоот тушаалаар төвийн төсөвт ор, орон тоог батлан гаргасан. Тус төв 2 эмнэлэг, 2 зөвлөх поликлиник, төрөлжсөн мэргэжлийн 32 тасаг, өсвөр үеийн клиник, үргүйдэл нөхөн үржихүйн төв, анагаахын удам зүйн лаборатори, Дэмжих үйлчилгээний 20 албатай үйл ажиллагаа явуулж байна. • Нийт 680 ортой. Эх барих эмэгтэйчүүдийн 256, Хүүхдийн төрөлжсөн мэс заслын 151, хүүхдийн дотрын 273 ортой. • Нийт 1270 орон тоо батлагдсан. Үүнд: • Эх барих эмэгтэйчүүдийн эмнэлэг 296, Хүүхдийн төрөлжсөн мэс заслын эмнэлэг 290, Хүүхдийн дотрын эмнэлэг 342, Дэмжих үйлчилгээний алба 342 орон тоотой. • 289 эмч, 415 сувилагч, 80 эх баригч, дүрс оношилгооны техникч 8, хөдөлгөөн засалч 18, био анагаах судлаач 2, лаборант 30, эм зүйч 23,

		эм найруулагч 2, туслах сувилагч 11, үйлчлэгч 153, бусад 239 орон тоо батлагдсан байна. • 2025 онд 1052 эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажилласан байна. Үүнд удирдах 1, гүйцэтгэх 774, туслах 273. • 2025 онд сул чөлөөтэй ажлын байрны зарыг байгууллагын гадаад цахим хуудас, ЭМХТ, Хүний нөөцийн мэдээллийн самбар, зангиа.мн сайт, фэйс бүлгэм дээр тус тус 24 удаа шинэчлэн байршуулсан. • Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн сар бүрийн 8-ны дотор тухайн сарын хүний нөөцийн орон тоо, гүйцэтгэлийн мэдээг 2025 онд www.shilendans.gov.mn 12 удаа байршуулсан. • 2025 оны 11 сарын гүйцэтгэлээр 1052 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, албан хаагч ажиллаж байна. Албан тушаалаар авч үзвэл: 263 эмч, 314 сувилагч, 72 эх баригч, дүрс оношилгооны техникч 9, хөдөлгөөн засалч 6, био анагаах судлаач 2, лаборант 22, эм зүйч 14, эм найруулагч 2, туслах сувилагч 30, үйлчлэгч 121, бусад 199 ажиллаж байна. Хүний нөөцийн хангалт 83%. Сувилагч 114 орон тоо дутуу. • Хүний нөөцийг сонгон шалгаруулахдаа хараат бус, бие даасан нээлттэй ил тод байдлыг баримтлан ажиллаж байна. Эмнэлэг, албадууд нь өөрсдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн орон тоог Хүний нөөцийн албаар оруулан, Ерөнхий захирлаар батлуулж, хүний нөөцийн төлөвлөлт, сонголтын үйл ажиллагаанд шаардлагатай тухай бүрт ажлын чиг үүргийн дагуу оролцдог. • Ерөнхий захирлын 2023 оны А/142 тоот тушаалаар “ЭХЭМҮТ-д эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан сонгон шалгаруулж авах журам”-ыг шинэчлэн баталсан. • Сонгон шалгаруулалтын журмын дагуу 2025 онд 154 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан ажилд шалгаруулан авсан байна. • 2025 онд шинээр ажилд орсон ажилчдын мэдээллийг гадаад вэб хуудсанд байршуулсан.
3	Стратегийн үйл ажиллагаа 3. Хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, хөгжил сургалтын тогтолцоог боловсронгуй болгох	ЭХЭМҮТ нь хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажилладаг. • Мэргэжлийн чиглэлээр давтан болон мэргэжил дээшлүүлэх сургалт эмнэлгийн удирдлагын бодлого, шийдвэрээр болон алба, тасаг нэгжээс ирүүлсэн хэрэгцээг харгалзан 2025 онд төрөлжсөн мэргэшлийн сургалтанд

		9 эмч, 8 сувилагч, мэргэжил дээшлүүлэх сургалтанд 5 эмч улсын төсвөөр суралцуулахаар шийдвэрлэсэн. Үүнд: Төрөлжсөн мэргэшлээр ○ Эх ураг судлал 1 ○ Эмэгтэйчүүдийн дотоод шүүрэл 1 ○ Зүрх судлал 1 ○ Хүүхдийн дүрс оношилгоо 1 ○ Хүзүү толгойн мэс засал 2 ○ Хүүхдийн эрчимт эмчилгээ 2 ○ Хүүхдийн сувилахуй 4 ○ Нярайн сувилахуй 3 ○ Гемодиализ 1 Мэргэжил дээшлүүлэх ○ Эх барих эмэгтэйчүүдийн хэт авиан оношилгоо 1 ○ Эмэгтэйчүүдийн дурангийн мэс засал 1 ○ Эмэгтэйчүүдийн мэс засал 1 ○ Эх барих эрчимт эмчилгээ 1 ○ Зүрхний хэм судал 1 • 2025 оны эхний хагас жилд 70 эмч, эмнэлгийн мэргэжилтэн гадаадын өндөр хөгжилтэй оронд 3-6 сарын мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдан, суралцах хугацаанд цалинтай чөлөө олгон, 5 жил тогтвор суурьшилтай ажиллах гэрээ байгуулсан • Ур чадварын үнэлгээ: Төвийн бүтэц зохион байгуулалт, чиг үүргийг тодорхойлон, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан улирал бүр 60 хүртэл хувийн урамшуулал олгож байна. • “Ажлын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт батлах тухай” ЭХЭМҮТ-ийн захирлын 2025.04.04.-ний А/39 тоот тушаал батлагдан гарсан. Тушаалыг төвийн вэб хуудсанд нээлттэй байршуулж, албан хаагчдад танилцуулсан. • Уг шалгуур үзүүлэлтийн дагуу тасаг, албадын дарга нарын ажлын гүйцэтгэлийг улирал бүр дүгнэж гүйцэтгэлийн үнэлгээгээг дүгнэнэ. • 2025 онд ажилчдын ажлын гүйцэтгэл үр дүнг үнэлэн улирал тутамд үндсэн цалингийн 60% хүртэлх хэмжээний урамшууллыг олгож ажилласан. 2025 оны үр дүнгийн урамшуулалд I улиралд 946 ажилтан 733.710.824 төгрөг, II улиралд 913 ажилтан 62764876977 төгрөг, III улиралд 916 ажилтан 597.759.476 төгрөг тус тус олгосон байна.
--	--	---

4	Стратегийн үйл ажиллагаа 4. Карьер хөгжлийн төлөвлөлтийг боловсруулан хэрэгжүүлэх	Хүний нөөцийн карьер хөгжлийн төлөвлөгөөтэй, ажлын гүйцэтгэлийн үнэлгээгээр албан тушаал дэвшүүлэх зорилго чиглэлийг баримтлан ажилладаг. 2025 онд 1 үйлчлэгчийг туслах сувилагчаар, 1 харуулыг ЭГХХХА, 1 харуулыг хүчилтөрөгчийн станцын цэнэглэгч, 2 сувилагчийг ахлах сувилагч, 1 хүний нөөцийн мэргэжилтэнг Хүний нөөцийн албаны даргаар, нийт 7 ажилтныг албан тушаал дэвшүүлсэн
---	---	---